

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2022.12.29

Улаанбаатар хот

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” /цаашид “нийтлэг журам” гэх/, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээний, үнэлгээ хийх журам” /цаашид “салбарын журам” гэх/-ын дагуу Цагдаагийн ерөнхий газраас 2022 онд хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулсан бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, салбарын журмын 3.2.3-т заасан үйл ажиллагааг үйл ажиллагааг хамруулан, хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэв.

Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт

Тайлант онд нийтлэг болон салбарын журмын 3.2.1-т заасан бодлогын баримт бичигт хамаарах 7, хамааруулаагүй 6 баримт бичгийг хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулсан нь дараах үр дүнтэй байна. Үүнд:

1.1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт:

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-нд тусгагдсан 23 үйл ажиллагааг хяналтад авч, хэрэгжилт тайлагнах чиглэл өгсний дагуу хэрэгжилтийг зохион байгуулж, хяналтад авсан бүх үйл ажиллагаанд оролцоогоо бүрэн хангасан байх тул үйл ажиллагаа тус бүрийг нийтлэг болон салбарын журмын 6.2.1-д заасан аргачлалын дагуу тооцож, 100 хувиар үнэлсэн.

Хэрэгжилтийн тайланг 2022 оны 3/419 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

1.2. Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилт:

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 8 үйл ажиллагаа, гуравдугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалт дахь 3 төслийг¹ хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулсан.

¹ **Тайлбар:** [Төслүүд Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлогын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалт”-д байхгүй, дээд байгууллагаас төслүүд хэрэгжихтэй холбоотой мэдээлэл ирүүлж, хяналтад авч, хэрэгжилт тайлагнахыг даалгаагүй бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яамны салбарын 2022 оны эхний хагас жилийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, Эдийн засаг, хөгжлийн яамны <https://dashboard.med.gov.mn> цахим хуудсанд тавигдсан Шинэ сэргэлтийн бодлогын төрийн бүтээмжийн сэргэлтийн 2022 оны эхний хагас жилийн мэдээллээс олж мэдсэн.]

Хөтөлбөрт тусгагдсан 8 үйл ажиллагаанд оролцоогоо бүрэн хангаж, тодорхойлсон үр дүнд хүрсэн бол хөгжлийн 3 төслийн тухайд санхүүжилт шийдвэрлүүлэх саналаа дээд байгууллагад хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй, төслийн хариуцагчаас даалгасан ажил, үүргийг тухай бүр гүйцэтгэн, төслийн хэрэгжилтэд оролцоогоо бүрэн хангасан байх тул хяналтад авсан 8 үйл ажиллагаа, 3 төслийн хэрэгжилт тус бүрийг нийтлэг болон салбарын журмын 6.2.1-д заасан аргачлалын дагуу тооцож, 100 хувиар үнэлсэн.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төслийн хэрэгжилтийн тайланг 2022 оны 03/478 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

1.3. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт:

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгагдсан 11 арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилт мэдээлэх чиглэл өгсний дагуу хэрэгжилтийг зохион байгуулсан нь зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээгүй, зорилтуудаа 1.0-1.2 дахин давуулан биелүүлсэн байх тул арга хэмжээ тус бүрийг нийтлэг болон салбарын журмын 6.2.1-д заасан аргачлалын дагуу тооцож, 100 хувиар үнэлсэн.

Үнэлгээг арга хэмжээ тус бүрээр хүснэгтэд харуулав.

Арга хэмжээний дугаар	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн түвшин			Үнэлгээ /хувь/
		суурь /2020 он/	зорилт /2022 он/	хүрсэн /2022 он/	
4.3.4	Мөнгө угаах гэмт хэргийн илрүүлэлт /тоогоор/	186	200	238	100
7.3.1	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн илрүүлэлт /хувиар/	51.9	52.0	54.1	100
7.3.2	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт /хувиар/	92	93.8	93.8	100
7.3.5	Иргэдэд зориулж нөлөөллийн аяныг зохион байгуулсан тоо	1	1	1	100
7.3.6	Бий болгох хүүхдийн байцаагч /орон тоогоор/	0	100	103	100
7.4.1	Төслийн хэрэгжилт /түвшингээр/	Улсын төсвөөр хэрэгжүүлэх ТЭЗҮ боловсруулсан.	Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх ТЭЗҮ боловсруулна.	Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх ТЭЗҮ боловсруулж, нийслэлд ашиглаж байгаа камеруудыг бүрэн нэгтгэсэн.	100

7.4.2	Хохирол барагдуулалт /сая төгрөгөөр/	82079.4	90000.0	90376.7	100
7.4.4	Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль /үйл ажиллагаагаар/	Хуулийн төсөл боловсруулсан.	Хуулийн төслийг УИХ- д өргөн мэдүүлсэн	Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн. Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолоор “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийг батлуулсан.	100
7.4.5	Бүртгэгдсэн мал хулгайлах гэмт хэргийн тоо	1041	767	767	100
7.4.7	Хууль сахиулах байгууллагууд иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих цахим нэгдсэн сүлжээ бий болгох	Холбогдох судалгаа, тооцоо хийсэн байна.	Холбогдох судалгаа, тооцооны 30 хувийг гүйцэтгэсэн байна.	Хууль зүй, дотоод хэргийн яаманд өдөр бүр тайлагнаж хэвшсэн.	100
7.5.1	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоо	-	-	235	100

Хэрэгжилтийн тайланг 2022 оны 3/461 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

1.4. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд Хууль зүй, дотоод хэргийн яам хариуцан, Цагдаагийн ерөнхий газар хамтран хэрэгжүүлэх, оролцохоор тусгагдсан 24, Тагнуулын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл тус тус хариуцан Цагдаагийн ерөнхий газар хамтран хэрэгжүүлэх, оролцохоор тусгагдсан 3, Цагдаагийн ерөнхий газар хамтран хэрэгжүүлэх, оролцох аль ч байдлаар тусгагдаагүй боловч цагдаагийн албаны оролцоотой хэрэгжих 4¹, дээд байгууллагаас хэрэгжилт тайлагнахыг мэдэгдснээр хяналтад авсан, Хууль зүй, дотоод хэргийн яам хариуцан, “Монголын сэтгүүлчдийн холбоо” хамтран хэрэгжүүлэх 1, нийт 32 арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулсан.

Дээд байгууллагаас хэрэгжилт тайлагнахыг мэдэгдснээр хяналтад авсан, “Хууль зүй, дотоод хэргийн салбарын цахим мэдээллийн төв байгуулна.” арга хэмжээний тухайд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд шууд хамааралгүй ба Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/237 дугаар

¹ 4.3.4.3, 4.3.5.2, 4.3.18.1, 4.4.8.1 дугаартай арга хэмжээ.

тушаалаар байгуулсан “Төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудын хэт богино долгионы радио станцуудыг шинэчлэх, нийслэл, орон нутгийн авто зам, уулзвар, гарц, хяналтын цэгүүдэд дэвшилтэт технологи бүхий теле хяналтын камер суурилуулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, нэгдсэн удирдлага бүхий хяналтын ухаалаг систем нэвтрүүлэх чиглэлээр судалгаа гаргах, төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог тодорхойлоход дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэд ажлын хэсэг”-ээс шинээр барих Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагуудын нэгдсэн “Дата төв”, “Видео аналитик, платформ систем”, “Ханан дэлгэцийн систем”, Дата төвийн сервер, сүлжээний тоног төхөөрөмж” болон “Орон нутгийн хатуу хучилттай автозам дагуу байрлах байнгын хяналтын 40 цэгийг /пост/-ийг камерын систем бүхий “Нэгдсэн удирдлага, хяналтын төв”-ийн барилгад салбарын цахим мэдээллийн төвийг байгуулахаар хэлэлцсэн, энэ барилга 4.3.2.3 дугаартай “Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлнэ.” арга хэмжээний хүрээнд хяналтад авагдаж, хэрэгжилт тайлагнажээ.

Барилгын зураг, төслийг хийхэд шаардагдах хөрөнгийг Барилга хот, байгуулалтын сайдын багцаас шийдвэрлүүлэн, зураг төсөл хийлгүүлж, Барилгын хөгжлийн төвөөр баталгаажуулан хүлээж авсан, бариулах зардлын тооцоог хийж, 2023 оны төсвийн төсөлд тусгуулахаар Хууль зүй, дотоод хэргийн болон Сангийн яаманд хүргүүлсэн боловч санхүүжилт шийдвэрлэгдээгүй байна.

Мөн “Согтууруулах ундааны эргэлт болон хэрэглээ, архидан согтууралтаас үүдэлтэй сөрөг үр дагаврыг бууруулах зорилгоор Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, УИХ өргөн мэдүүлнэ.”, “Шүүхийн шинжилгээ хийхтэй холбогдон үүсэж буй харилцааг цогц байдлаар шийдвэрлэх, байгууллагын удирдлага, зохион байгуулалт, бүтэц, статусыг тодорхойлох, байгууллага болон шинжээч мэргэжилтний бие даасан, хараат бус байдлыг хангах, гадны нөлөөнд автахгүй байх, албан хаагчдын нийгэм, эдийн засаг, эрх зүй, аюулгүй байдлын баталгааг хангах тогтолцоог бүрдүүлэх Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлнэ.” гэсэн 2 арга хэмжээ үр дүнд хүрч, хуулийн төслүүдийг Улсын Их Хурлаас хэлэлцэн баталсан.

Иймд 4.1.1.3 дугаартай шууд хамааралгүй 1 арга хэмжээг үндсэн хариуцагчийн хяналтад шилжүүлэх, 4.3.18.1, 4.4.7.4 дугаартай, үр дүнд хүрсэн 2 арга хэмжээг хэрэгжилт хангасанд тооцож, хяналтаас хасах саналтай байна.

Бусад 29 арга хэмжээний 20-ийнх нь хэрэгжилт 2020 оноос, 8-ынх нь хэрэгжилт 2021 оноос, 1-ийнх нь хэрэгжилт 2022 оноос эхэлж, 2023-2025 онд дуусахаар төлөвлөгдснөөс 14 арга хэмжээний хэрэгжилт 2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлтэд хүрсэн, 15 арга хэмжээний хэрэгжилтэд хариуцагчаас хэрэгжилтийг зохион байгуулсны дагуу ажиллаж, оролцоогоо бүрэн хангасан байх тул арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг нийтлэг болон салбарын журмын 6.2.1-д заасан аргачлалын дагуу тооцож, 100 хувиар үнэлсэн.

Үнэлгээг арга хэмжээ тус бүрээр хүснэгтэд харуулав.

№	Арга хэмжээний дугаар	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлтэд хүрсэн	Оролцоогоо бүрэн хангасан	Хяналтаас хасах саналтай	Үнэлгээ /хувиар/
1	2.6.3.7	√			100
2	4.1.1.2		√		100
3	4.1.1.3			√	100

4	4.1.6.6	√			100
5	4.2.1.1	√			100
6	4.2.5.3	√			100
7	4.3.2.1		√		100
8	4.3.2.2	√			100
9	4.3.2.3		√		100
10	4.3.2.4		√		100
11	4.3.2.5	√			100
12	4.3.2.6	√			100
13	4.3.2.7		√		100
14	4.3.3.1		√		100
15	4.3.3.2	√			100
16	4.3.4.2	√			100
17	4.3.4.3		√		100
18	4.3.4.4	√			100
19	4.3.4.5		√		100
20	4.3.5.1	√			100
21	4.3.5.2		√		100
22	4.3.9.1		√		100
23	4.3.10.1		√		100
24	4.3.18.1			√	100
25	4.4.7.1		√		100
26	4.4.7.2	√			100
27	4.4.7.3		√		100
28	4.4.7.4			√	100
29	4.4.7.5		√		100
30	4.4.8.1		√		100
31	4.4.12.1	√			100
32	5.1.10.1	√			100

Хэрэгжилтийн тайланг 2022 оны 3/343 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

1.5. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т Хууль зүй, дотоод хэргийн яам хариуцсан 114 дугаартай “Улаанбаатар

хот, аймгийн төвийн гудамж талбайг камержуулах төсөл”, 115 дугаартай “Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх”, 116 дугаартай “Цагдаагийн байгууллагын хэт богино долгионы радио холбооны шинэчлэл хийх”, 117 дугаартай “Цагдаагийн байгууллагын авто парк шинэчлэл” гэсэн 4 төсөл, арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулсан.

Эдгээр төсөл, арга хэмжээний 3-ын санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөв, 1-ийг гадаадын зээл тусламж /хөнгөлттэй зээл/, хэрэгжих хугацааг 2019-2024 он гэж тодорхойлон, жил бүр хуваарийн дагуу санхүүжүүлэхээр хөтөлбөрт тусгагдсан, энэ дагуу Цагдаагийн ерөнхий газраас жил бүр хөрөнгө шийдвэрлүүлэх санал хүргүүлж байгаа ч “Цагдаагийн байгууллагын авто парк шинэчлэл”-ээс бусад хөтөлбөрийн хөрөнгө шийдвэрлэгдээгүй.

Тайлант онд “Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх”, “Улаанбаатар хот, аймгийн төвийн гудамж талбайг камержуулах” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай 737.2 тэрбум, “Цагдаагийн байгууллагын хэт богино долгионы радио холбооны шинэчлэл хийх” төсөл, арга хэмжээний хэт богино долгион, радио сувагчлал хийх 75.1 тэрбум төгрөгийг тус тус Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хязгаарт тусгуулах саналыг хүргүүлсэн боловч Улсын Их Хурлаар төсөв хэлэлцэж, батлах үед хасагдсан ба “Цагдаагийн байгууллагын авто парк шинэчлэл” төсөл арга хэмжээгээр 2.1 тэрбум төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 оноос хойш ашиглаж байгаа автомашины 40 орчим хувийг шинэчлэсэн.

Дээрх байдлаар төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд өөрөөс хамаарах арга хэмжээг бүрэн авч, оролцоогоо хангасан байх тул төсөл, арга хэмжээ бүрийн хэрэгжилтийг 100 хувиар үнэлсэн.

Хэрэгжилтийн тайланг 2022 оны 03/461 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

1.6. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт:

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Монгол Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд Хууль зүй, дотоод хэргийн яам хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан 3, Шадар сайд хариуцан, Хууль зүй, дотоод хэргийн яам хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан 1, нийт 4 арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилт тайлагнах чиглэл өгсний дагуу хэрэгжилтийг зохион байгуулсан.

“Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх” арга хэмжээгээр 60 цэг хяналтад авахаас 68 цэгийг хяналтад авч, тодорхойлсон зорилтыг хангасан.

“Дотоодын цэргийн хамгаалалтад шилжээгүй дулааны цахилгаан станц, стратегийн орд, ус хангамжийн эх үүсвэрийн объектыг хамгаалалтад авах” арга хэмжээгээр усны эх үүсвэрийн 4, цахилгаан станцын 1, стратегийн ордын 2, нийт 7 объект шинээр хамгаалалтад авахаас 6 объектыг хамгаалалтад авсан, нийслэлийн Баянхошууны хөтөлийн усан санд туршилт хийгдээгүй учраас 2022 онд ашиглалтад оруулахгүй байхаар Ус сувгийн удирдах газар шийдвэрлэсэнтэй холбоотойгоор объектыг хамгаалалтад авах ажил хүлээлтэд байна. Уг арга хэмжээний хэрэгжилтийн удаашрал дотоодын цэргийн үйл ажиллагаанаас шалтгаалаагүй учраас зорилтыг хангасанд тооцсон.

“Туул голын хамгаалалтын бүсэд орших түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагааг таслан зогсоож, аж ахуйн нэгжээр нөхөн сэргээлт хийлгэх” арга хэмжээгээр энэ бүсийн эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг 30-аас

доошгүй хувьд хийлгэсэн байх зорилт тодорхойлогдсон нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаагаар шууд хангагдах бололцоогүй ба цагдаагийн байгууллага тодорхойлсон бүсэд үйл ажиллагаа явуулсан 4 зөрчлийг илрүүлэн, холбогдох шалгалтын ажиллагааг явуулж, харьяаллын дагуу мэргэжлийн хяналтын байгууллагад шилжүүлж, “Цахим архив албан хэрэг хөтлөлт” арга хэмжээний төслийг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах, архивын нэгжийн цахимжуулалтыг эрчимжүүлэх арга хэмжээгээр улсын хэмжээнд шинээр 100.000 архивын нэгж цахимжуулахаас цагдаа, дотоодын цэргийн байгууллага төрийн архивын программд 513 архивын нэгж цахимжуулан, цахимжсан 625 архивын нэгжид тодорхойлон бичилт хийж, 1067 архивын нэгжийг засварлан, тус тус оролцоогоо хангасан байна.

Иймд хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулсан арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг нийтлэг болон салбарын журмын 6.2.1-д заасан аргачлалын дагуу тооцож, 100 хувиар үнэлсэн.

Үнэлгээг арга хэмжээ тус бүрээр хүснэгтэд харуулав.

№	Арга хэмжээний дугаар	Зорилтыг бүрэн хангасан	Өөрөөс хамаарах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн	Оролцоогоо бүрэн хангасан	Үнэлгээ /хувиар/
1	4.1.7.			√	100
2	4.3.10.		√		100
3	4.3.17.	√			100
4	5.1.14.			√	100

Төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 3/465 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

1.7. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт:

Хууль, зүй дотоод хэргийн сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-нд Цагдаагийн ерөнхий газар хариуцсан 21 арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулсан.

Стратеги төлөвлөгөөний явцын хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын дагуу 2022 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн гаргаж, нийтлэг журмын 6.2.1-д заасан аргачлалаар тооцоход 49.0 хувийн хэрэгжилттэй ба үүнийг тайлант хугацааны төлөвлөсөн түвшинд нь тооцож, 98.0 хувь гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн дагуу бүх арга хэмжээний хэрэгжилт 2021 онд эхэлж, 2024 онд дуусах бөгөөд 17 арга хэмжээний хэрэгжилт тайлант оны зорилтот түвшинд хүрсэн, 4 арга хэмжээний хэрэгжилт Төрийн хэмнэлтийн тухай хуульд батлагдсантай холбогдуулан төсөв, санхүүгээс шалтгаалж, удааширсан ч төлөвлөсөн хугацааны дотор хэрэгжилт бүрэн хангах бололцоотой, хэрэгжилт эхлээгүй, тасарсан арга хэмжээ байхгүй байна.

Хэрэгжилтийн тайланг 2022 оны 3/460 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

1.8. Нийтлэг болон салбарын журмаар бодлогын баримт бичигт хамааруулаагүй баримт бичгийн хэрэгжилт:

Тайлант онд нийтлэг болон салбарын журмаар бодлогын баримт бичигт хамааруулаагүй 6 хөтөлбөрийг хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулснаас Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолоор баталсан “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр” 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан бөгөөд хөтөлбөр баталсан шийдвэрт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлд даалгасны дагуу Үндэсний зөвлөл 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдөр хуралдаж, төлөвлөгөөг баталсан.

Энэ төлөвлөгөөг үндэслэн цагдаагийн байгууллагаас хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар төлөвлөгөө боловсруулан баталж, мөрдсөн тул тайлант онд хэрэгжилт тооцох бололцоогүй.

Бусад 5 хөтөлбөрийн тухайд Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-т тусгагдсан, цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бүх үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж, хэрэгжилтийг тайланг 2022 оны 3/463 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд, Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолоор баталсан “Гэрч, хохирогчийг хамгаалах, тусламж үзүүлэх үндэсний хөтөлбөр”, 2020 оны 141 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн хөгжлийн хөтөлбөр”-ийг тус тус 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж, биелэлтүүдийг 2022 оны 3/478 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд, Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор баталсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг 2022 оны 2/512 дугаартай албан бичгээр Хууль зүйн үндэсний хүрээлэнд тус тус хүргүүлж, Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээний цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 92.0 хувьтай хэрэгжүүлж, Авлигын эсрэг үндэсний сүлжээний khutulbur.iaас.mn цахим хуудсанд байршуулсан.

Хоёр. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Тайлант онд нийтлэг болон салбарын журмын 3.2.2-т заасан, хууль тогтоомж, тогтоол шийдвэрт хамаарах Монгол Улсын 7 хууль, Монгол Улсын Их Хурлын 4 тогтоол, Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 7 тогтоол, Ерөнхийлөгчийн 4 зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 3 зөвлөмж, Засгийн газрын 18 тогтоол, Ерөнхий сайдын 5 захирамж, Засгийн газрын хуралдааны 33 тэмдэглэл, Засгийн газрын 7 албан даалгавар, нийт 88 шийдвэрийн 187 заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулсан.

Үүнээс 5 шийдвэрийн 18 заалтыг бүрэн хэрэгжүүлж дууссан, үе шаттайгаар болон тогтмол хэрэгжих 84 шийдвэрийн 169 заалтыг 2022 онд төлөвлөсөн хэмжээнд нь буюу зорилтот түвшнийг хангаж, хэрэгжүүлсэн байх тул хяналтад авсан шийдвэрүүдийн бүх заалтын хэрэгжилтийг нийтлэг болон салбарын журмын 6.2.1-д заасан аргачлалын дагуу тооцож, 100 хувиар үнэлсэн.

Бүрэн хэрэгжүүлж дууссан 5 шийдвэрийн 18 заалтыг хяналтаас хасч, үе шаттайгаар болон тогтмол хэрэгжих 84 шийдвэрийн 169 заалтыг үргэлжлүүлэн хяналтад авч, хэрэгжилтийг хангах саналтай байна.

Үнэлгээг шийдвэрийн зүйл, заалт тус бүрээр хүснэгтэд харуулав.

№	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр	Заалтын тоо	Хэрэгжилтийн байдал		Үнэлгээ /хувиар/	
			Бүрэн хэрэгжүүлж дууссан	2022 онд төлөвлөсөн хэмжээнд нь хэрэгжүүлсэн		
1	Нэг. Монгол Улсын хууль	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай	1		1	100
2		Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай /Шинэчилсэн найруулга/	1		1	100
3		Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/	2		2	100
4		Зөрчил шалган шийдвэрлэх тухай	1		1	100
5		Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/	1		1	100
6		Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай /Шинэчилсэн найруулга/	3		3	100
7		Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай	5	5		100
8	Хоёр. Улсын Их Хурлын тогтоол	2019 оны “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 62 дугаар	2		2	100
9		2020 оны “Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 39 дүгээр	1		1	100
10		2022 оны “Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” 08 дугаар	5		5	100
11		2021 оны “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 67 дугаар	8	3	5	100
12	Гурав. Улсын Их Хурлын Байнгын	2012 оны “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээний тухай” 05 дугаар	2		2	100

13	хорооны тогтоол	2013 оны “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 11 дэх илтгэлийг хэлэлцсэн тухай” 02 дугаар	1		1	100
14		2015 оны “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 28 дугаар	2		2	100
15		2018 оны “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар	4		4	100
16		2018 оны “Чиглэл өгөх тухай” 06 дугаар	2		2	100
17		2019 оны “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай /шинэчилсэн найруулга/ хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 07 дугаар	4		4	100
18		2021 оны “Зөвлөмж, чиглэл өгөх тухай” 02 дугаар	1		1	100
19		2018 оны “Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 46 дугаар	1		1	100
20	Дөрөв. Ерөнхийлөгчийн зарлиг	2019 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 60 дугаар	8		8	100
21		2019 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 104 дүгээр	8	8		100
22		2022 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 43 дугаар	5		5	100
23	Тав. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	2010 оны “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай” 10/03 дугаар	1		1	100
24		2018 оны “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” 06/05 дугаар	10		10	100

25		2019 оны “Татвараас зайлсхийх, мөнгө угаах гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” 47/33 дугаар	2		2	100
26	Зургаа. Засгийн газрын тогтоол	2021 оны “Талын зам” үндэсний хөтөлбөр батлах тухай 142 дугаар	1		1	100
27		2021 оны “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө батлах тухай” 42 дугаар	4		4	100
28		2021 оны “Замын-Үүд чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд шилжүүлэх тухай” 223 дугаар	2		2	100
29		2021 оны “Дотоодын цэргийн анги байгуулах” 356 дугаар	1	1		100
30		2021 оны “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 388 дугаар	2		2	100
31		2022 оны “Журам шинэчлэн батлах тухай” 1 дүгээр	1		1	100
32		2022 оны “Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 7 дугаар	5		5	100
33		2022 оны “Хилийн Замын-Үүд авто замын боомтод авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 27 дугаар	3		3	100
34		2022 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” 129 дүгээр	1		1	100
35		2022 оны “Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай” 139 дүгээр	2		2	100
36		2022 оны “Концессын гэрээ цуцлах тухай” 148 дугаар	1		1	100
37		2022 оны “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 203 дугаар	4		4	100

38		2022 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр	2		2	100
39		2022 оны “Журамд нэмэлт оруулах тухай” 248 дугаар	1		1	100
40		2022 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 277 дугаар	1		1	100
41		2022 оны “Үндэсний хорооны ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” 247 дугаар	1		1	100
42		2022 оны “Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 413 дугаар	1		1	100
43		2022 оны “Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 450 дугаар	2		2	100
44		2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 86 дугаар	1		1	100
45		2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 112 дугаар	1		1	100
46	Долоо. Ерөнхий сайдын захирамж	2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 113 дугаар	1		1	100
47		2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 114 дүгээр	1		1	100
48		2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 213 дугаар	1		1	100
49		2020 оны 9 дүгээр сарын 16-ний өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэл	1		1	100
50	Найм. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 59 дүгээр тэмдэглэл	8		8	100
51		2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны 69 дүгээр тэмдэглэл	1		1	100
52		2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 38 дугаар тэмдэглэл	1		1	100

53	2021 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 46 дугаар тэмдэглэл	1		1	100
54	2021 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэл	2		2	100
55	2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэл	2		2	100
56	2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 55 дугаар тэмдэглэл	3		3	100
57	2021 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн хуралдааны 62 дугаар тэмдэглэл	2		2	100
58	2021 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 63 дугаар тэмдэглэл	1		1	100
59	2022 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны 9 дүгээр тэмдэглэл	3		3	100
60	2022 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 11 дүгээр тэмдэглэл	1		1	100
61	2022 оны 3 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэл	2		2	100
62	2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдааны 21 дүгээр тэмдэглэл	1		1	100
63	2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл	1		1	100
64	2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 24 дүгээр тэмдэглэл	2		2	100
65	2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 27 дугаар тэмдэглэл	2		2	100
66	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэл	1		1	100
67	2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны 30 дугаар тэмдэглэл	1		1	100
68	2022 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 32 дугаар тэмдэглэл	1		1	100
69	2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 33 дугаар тэмдэглэл	3		3	100

70		2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэл	1		1	100
71		2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны 35 дугаар тэмдэглэл	1		1	100
72		2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуралдааны 36 дугаар тэмдэглэл	1		1	100
73		2022 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 38 дугаар тэмдэглэл	1		1	100
74		2022 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэл	1		1	100
75		2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны 42 дугаар тэмдэглэл	1		1	100
76		2022 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 45 дугаар тэмдэглэл	1	1		100
77		2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааны 47 дугаар тэмдэглэл	4		4	100
78		2022 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн хуралдааны 48 дугаар тэмдэглэл	1		1	100
79		2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэл	1		1	100
80		2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны 57 дугаар тэмдэглэл	1		1	100
81		2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хуралдааны 58 дугаар тэмдэглэл	1		1	100
82	Ес. Засгийн газрын албан даалгавар	2021 оны “Бүтээн байгуулалтын төсөл, бодлогын зарим арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр	2		2	100
83		2022 оны “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, хөгжлийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр	1		1	100

84	2022 оны “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд шинээр эхлэн санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг эрчимжүүлэх тухай” 02 дугаар	3		3	100
85	2022 оны “Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай” 03 дугаар	2		2	100
86	2022 оны “Цаг үеийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай” 05 дугаар	2		2	100
87	2022 оны “Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай” 06 дугаар	1		1	100
88	2022 оны “Сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлэх, өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” 08 дугаар	1		1	100

Хэрэгжилтийн тайланг 2022 оны 3/471 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Гурав. Байгууллагын үйл ажиллагаа

Салбарын журмаар байгууллагын үйл ажиллагаанд хамааруулсан бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үнэлгээний талаар тайлангийн 1, 2 дахь хэсэгт, стратеги төлөвлөгөөний биелэлтийг 1.7 дахь хэсэгт тус тус тайлагнасан.

Тайлант онд Хууль зүй, дотоод хэргийн сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар үүрэг даалгавар өгөөгүй, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан, Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ байхгүй байна.

3.1. Сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлт:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 5 шуурхай хуралдаанаас өгсөн 58 үүрэг, даалгаварыг хугацаанд нь бүрэн биелүүлж, тухай бүр биелэлт мэдээлж ажилласан байх тул хуралдаан бүрээс өгсөн үүрэг, даалгаварын биелэлтийг нийтлэг журмын 6.2.1-д заасан аргачлалаар тооцож, 100 хувиар үнэлсэн.

Үнэлгээг хуралдаан тус бүрээр хүснэгтэд харуулав.

№	Шуурхай хуралдаан	Өгсөн үүрэг даалгаврын тоо	Биелэлт хүргүүлсэн албан бичиг	Биелэлт /хувиар/
1	2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн	22	2022 оны 3/303	100
2	2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн	19	2022 оны 2/239	100

3	2022 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн	8	2022 оны 3/154	100
4	2022 оны 01 дугаар сарын 31-ны өдрийн	9	2022 оны 3/82	100

3.2. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт:

Засгийн газрын 2018 оны 55 дугаар тогтоолоор Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор яамдын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, эдгээрийн 2017, 2018, 2019, 2020 онуудын зорилтот түвшинг тодорхойлж, баталсан.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдох салбарын үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхойлж, баталсан шийдвэр гараагүй.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан яамдын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг боловсруулж байгаатай холбогдуулан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарах Хууль зүй, дотоод хэргийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, түүний хүрэх түвшингийн төслийг тодорхойлж ирүүлэхийг 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 3/2172 дугаартай албан бичгээр мэдэгдсэн.

Энэ дагуу Цагдаагийн ерөнхий газраас өмнөх онуудад хяналтад авч, ханган ажилласан 2 үзүүлэлтийг хэвээр үлдээж, үзүүлэлтүүдийн суурь түвшинг 2020 оны эхний 11-н сарын байдлаар тогтоох, зорилтот түвшинг Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудыг мөрдснөөс хойших хугацааны жилийн дундаж өсөлтийг харгалзан “Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь” үзүүлэлтийг жилд 1-ээр, “Эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлийн илрүүлэлтийн хувь” үзүүлэлтийг жилд 2-оор нэмэгдүүлэх саналыг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 01/987 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Хүргүүлсэн саналыг хүснэгтэд харуулав.

№	Үзүүлэлт	Суурь түвшин /2020 оны эхний 11 сар/	Зорилтот түвшин			
			2021 он	2022 он	2023 он	2024 он
1	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	48.6	49.6	50.6	51.6	52.6
2	Эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлийн илрүүлэлтийн хувь	76.6	78.6	80.6	82.6	84.6

Иймд хүчин төгөлдөр мөрдөж байгаа Засгийн газрын 2018 оны 55 дугаар тогтоолоор баталсан “Яамдын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”, хүргүүлсэн саналаа үндэслэн Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн тодорхойлж, үнэлсэн.

Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь 2022 оны эхний 11 сарын байдлаар¹ 54.2 байгаа нь саналд тодорхойлсон 2022 оны зорилтоос 4.2-оор, 2021 онд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь 52.7 байсныг суурь болгож, саналд тодорхойлсон жилд 1-ээр нэмэгдүүлэх зорилтоос 1.5-аар тус тус их, эрэн сурвалжлагдаж байгаа хүн,

¹ **Тайлбар:** [Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь үзүүлэлт Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээллийн санд бүртгэгддэг, үзүүлэлтийн жилийн эцсийн мэдээг 12 дугаар сарын 31-ний өдрийн 18:00 цагаар тасалбар болгож, бүртгэхээр журамласан, энэ тайланг журмаар тогтоосон хугацаанаас өмнө ирүүлэх ажлын чиглэл хүлээн авсантай холбоотойгоор тайлант оны эхний 11 сарын мэдээг ашиглав.]

эд зүйлийн илрүүлэлтийн хувь үзүүлэлтийн тухайд 2022 онд 80.9 байгаа нь саналд тодорхойлсон 2022 оны зорилтоос 0.3-аар, 2021 онд эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлийн илрүүлэлтийн хувь 78.7 байсныг суурь болгож, саналд тодорхойлсон жилд 2-ээр нэмэгдүүлэх зорилтоос 2.2-аар тус тус их байгаа тул үзүүлэлт тус бүрийг нийтлэг болон салбарын журмын 6.2.1-д заасан аргачлалын дагуу тооцож, 100 хувиар үнэлсэн.

3.3. Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт:

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулан, дотоод аудитаар баталгаажуулан, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар хянуулан, баталж, мөрдсөн.

Тайлант онд 5 зорилтын хүрээнд 68 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-д зааснаар хяналт шинжилгээ хийж, төлөвлөсөн ажил, арга хэмжээний хэрэгжилтийг нийтлэг журмын 6.2.1-д заасан аргачлалаар тооцож, 61 ажил, арга хэмжээг 100 хувь, 2 арга хэмжээг тус бүр 95 хувь, 1 арга хэмжээг 93.3 хувь, 2 арга хэмжээг тус бүр 90 хувь, 2 арга хэмжээг тус бүр 80 хувиар, төлөвлөгөөний биелэлтийг 98.8 хувиар үнэлсэн.

Хэрэгжилт бүрэн хангагдаагүй арга хэмжээнүүдийн тухайд Төрийн хэмнэлтийн тухай хуульд батлагдсантай холбогдуулан төсөв, санхүүгээс шалтгаалан удааширсан байх бөгөөд гүйцэтгэлийг хангахаар 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлд тусгасан.

Гүйцэтгэлийн тайланг 2022 оны 01/814 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

3.4. Ил тод байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт:

Нээлттэй байдлыг хангах чиглэлээр Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Төсвийн тухай хуулиуд, Засгийн газрын 2009 оны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” 143, 2015 оны “Төрийн үйлчилгээний цахим машины талаар авах зарим арга хэмжээний тухай” 23, 2020 оны “Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 90 дүгээр тогтоолууд, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарын 2020 оны А/39 дүгээр тушаалаар баталсан “Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам”-ыг хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа мэдээллийн ил тод байдлын хангах харилцааг зохицуулан, журамлаж¹ мөрдснөөр иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах нөхцлийг бүрдүүлэн ажилласан байна.

¹ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны а/246 дугаар тушаалаар “Мэдээллийн тл тод байдлыг хангах, сурталчлах (код 135) журам” баталж, журмыг 2020 оны а/255 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.

Ил тод байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилтийг нийтлэг журмын 9 дүгээр хавсралтад заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийн 5 хэсэг, 46 шалгуур үзүүлэлтээр, нийтлэг журмын 6.2.1-д заасан аргачлалаар тооцоход бүх шалгуурыг хангасан байх тул 100 хувиар үнэлсэн.

Хэрэгжилтийн тайланг хавсаргав.¹

3.5. Шилэн данс хөтлөлт:

Тайлант онд цагдаа, дотоодын цэргийн 54 байгууллага 20 төрлийн 8586 мэдээллийг шилэнд дансны цахим хуудаст байршуулж, мэдээлэхээс 8497 хугацаанд нь, 89-ийг хугацаа хоцроосон, 108-ийг мэдээлэх хугацаа болоогүй ба мэдээлэл байршуулсан хугацааны байдлыг шалгуур үзүүлэлт болгож, шилэн данс хөтлөлтийг үнэлэхэд 99.0 хувьтай байна.

Шилэн данс хөтлөлтийн тайланг 2022 оны 3/479 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

3.6. Шударга байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт:

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д зааснаар Авлигатай тэмцэх газар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Авлигатай тэмцэх газраас 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр зарласан “Шударга байдлын үнэлгээ-2021” судалгаагаар Цагдаагийн ерөнхий газар 73.4 оноогоор үнэлэгдсэн ба үүнээс хойш хийгдсэн судалгаа байхгүй байна.

Төрийн байгууллагын шударга байдалд гарч буй өөрчлөлтийг ажиглахад улсын дундаж үнэлгээ чухал ач холбогдолтой бөгөөд Авлигатай тэмцэх газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/123 дугаар тушаалаар шударга байдлын үнэлгээний аргачлалыг шинэчлэн баталж, мөрдсөн.

Аргачлал шинэчлэгдснээс хойш хийгдсэн анхны судалгаагаар Цагдаагийн ерөнхий газар улсын дундажаас доогуур байсан бол дараагийн судалгаануудад улсын дундажаас байнга дээгүүр үнэлэгдсэн, 2021 оны судалгаанд өмнөх 2 судалгаагаар гаргаж байсан тогтмол ахицаа нэмэгдүүлсэн үр дүнтэй байна.

Үнэлгээг судалгаа тус бүрээр харуулав.

Шударга байдлын үнэлгээ	Улсын дундаж үнэлгээ	Цагдаагийн ерөнхий газрын үнэлгээ	Улсын дундажтай харьцуулсан үр дүн
2016	69.7	62.0	7.7 оноогоор доогуур ↓
2018	68.7	69.2	0.5 оноогоор дээгүүр ↑
2019	74.1	74.6	0.5 оноогоор дээгүүр ↑
2021	72.9	73.6	0.7 оноогоор дээгүүр ↑

Шударга байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг ... дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

¹ Тайлангийн 1 дүгээр хавсралт.

3.7. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт:

Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд алба хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр тусган хэрэгжүүлсэн зорилтын биелэлтийг нийтлэг журмын 4 дүгээр хавсралтад заасан 7 үйл ажиллагааны үндсэн 14, дэд 8 шалгуур үзүүлэлтээр, хэмжихэд бүгд зорилтот түвшиндээ хүрсэн байх тул 100 хувиар үнэлсэн.

Биелэлтийн тайланг хавсаргав.¹

3.8. Хэрэглэгчийн үнэлгээ:

Нийтлэг журмын 3.2.3.11-т заасны дагуу мөн журмын 11.4, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээний, үнэлгээ хийх журам”-ын 9.4-т заасан шаардлага хангаж, хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх ажлын зохион байгуулсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалаар баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг баримтлан, “Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны хэрэглэгчийн үнэлгээ хийх ажлын удирдамж”-ийг боловсруулж, батлан, судалгааны болон хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудаас ажлын туршлага, хүний нөөцийн хүчин чадал зэргийг нь харгалзан, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу “Ажиглалт” нийгэмд үйлчлэдэг төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулж, хэрэглэгчийн үнэлгээг хийлгэн, тайланг 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр хүлээн авсан.

Үнэлгээгээр Цагдаагийн ерөнхий газраас 2022 онд хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, иргэдэд хүргэсэн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлын талаар иргэдийн хандлагыг тандан судлаад, 92.75 хувь буюу 4.6 оноогоор үнэлж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 онд хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын онц чухал объектыг хамгаалах үндсэн чиг үүрэг, дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан гэж дүгнээд, иргэдийн сэтгэл ханамж өндөр байгаа нь мэргэжлийн удирдлага, зохион байгуулалт, нийгмийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлж буй олон талт үйл ажиллагаатай нь холбоотой гэж үзсэн ба согтуугаар, гудамж, талбай олон нийтийн газарт үйлдэгдсэн болон зарим төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийг нэмэгдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, үр дүнг нь тооцоход анхаарах чиглэлээр зөвлөмж өгсөн.

Хэрэгжилтийн үнэлгээний тайланг 2022 оны 3/464 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Дөрөв. Дүгнэлт, зөвлөмж

Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг нийтлэг журмын 6.2.1-д заасан аргачлалаар тооцож, нийтлэг журмын 6 дугаар хавсралтад зааснаар үйл ажиллагааны үнэлгээг дүгнэхэд “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт үнэлгээ” 100 хувь, “Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ” 99.4 хувь, “Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ” 91.3 хувь байх бөгөөд “Байгууллагын үйл ажиллагааны үнэлгээний дүн” 98.1 хувь буюу

¹ Тайлангийн 2 дугаар хавсралт.

4.9 оноотой байна.

Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны үнэлгээний дүнг хавсаргав.¹

Тайлант онд цагдаа, дотоодын цэргийн байгууллага Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын онц чухал объектыг хамгаалах үндсэн чиг үүргийн хүрээнд 2022 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Байгууллагын төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахтай холбоотой чухал арга хэмжээг авч хэрэгжүүлснийг онцлон тэмдэглэвэл:

Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн чуулганаар батлан, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх болж, захиргаа, санхүү, мэдээлэл дүн шинжилгээний албанд ажилласан алба хаагч, ахмад ажилтны эрх зүйн байдлыг дээрдүүлсэн эрх зүйн шинэчлэлт хийгдсэн.

Засгийн газрын 2022 оны 452 дугаар тогтоолоор цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын цалинг 28.8-аас 77.0 хувиар нэмэгдүүлсэн.

Жагсаал, цуглааны хамгаалалт, зохицуулалтад ажилласан алба хаагчдын урамшуулалд 4,2 тэрбум, нэг бүрийн хамгаалах тусгай хэрэгсэл болон бусад техник хэрэгсэл, гудамж талбайн камер, тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн 9.1 тэрбум, нийт 13.3 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлсэн.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын “СӨРГӨ-2022” стратегийн команд штабын нэгдсэн сургуульд оролцож, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг дээшлүүлэх, онцгой нөхцөл байдлын үед хамтран үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх, харилцан ажиллагааны уялдаа холбоог сайжруулахад суралцан, туршлага хуримтуулсан.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Нямыянжу хотын Эль эмнэлэг, Квангжу хотын Чамчуван эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, алба хаагч, гэр бүлийн гишүүдэд нь хөнгөлттэй үнээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг авах боломжийг бүрдүүлсэн зэргээр алба хаагчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх, албан үүргээ гүйцэтгэх, албаны бэлэн байдлыг хангах чиглэлээр ихээхэн ахиц гаргасан байна.

Үйл ажиллагааны чиглэлээр байгууллагын ерөнхий гүйцэтгэлийг сайжруулах, тогтвортой хөгжлийн санаачлагын суурь бий болгох зорилгоор чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх стратеги шийдвэр гаргаж, туршилтын шатанд Дундговь аймгийн цагдаагийн газрын үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 олон улсын стандартыг нэвтрүүлж, 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай итгэмжлэн баталгаажуулсан MC47/QMS 170 22 гэрчилгээ олгосон нь цаашид удирдлагын тогтолцооны стандартуудыг цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлж ажиллах, ажил үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах, байгууллагын соёлыг бий болгон байгууллагын үр ашиг, үнэлэмжийг тогтмол нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн.

Криминологи судалгааны “ArcGis” программын хэрэглээг нэмэгдүүлж, 32 алба хаагчийг судалгаа хийх мэргэшүүлэх сургалтанд хамруулан, судалгааны дүнг гэмт хэргийн гаралтыг бууруулахад үр дүнтэй ашигласан.

¹ Тайлангийн 3 дугаар хавсралт

Бичиг хэрэг, архивын нэгдсэн “eАрхив” программ хангамжийг нэвтрүүлэн, тасгийн дарга болон түүнээс дээш албан тушаалтай 551 алба хаагчид цахим гарын үсэг олгож, дотооддоо цахим хэлбэрээр албан бичиг солилцон, төрийн байгууллагууд хооронд албан бичиг илгээх, хүлээн авахад шаардагдах цаг хугацаанаас үүдэлтэй хүндрэл, бэрхшээлийг багасгах нөхцлийг бүрдүүлсэн, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 1649 цахим шуудангийн хаягийг үүсгэж, төрийн байгууллага, алба хаагчид албан ёсны төрийн цахим шууданг хэрэглэж хэвшүүлэх ажлыг эхлүүлсэн, жолоодох эрхийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа системийг шинэчлэн, дотоод үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, алба хаагчийн ажлын ачааллыг бууруулсан, “PoliceSOP” программ хангамжийг “Android”, “Apple IOS” үйлдлийн системтэй гар утас, таблетэд зориулсан хувилбаруудыг боловсруулж, “Google play store”, “Apple store” дээр байршуулан, алба хаагч гар утаснаасаа албаны мэдээ, мэдээлэл авах бололцоотой болгосон, төрийн байгууллагын мэдээлэл солилцооны “ХУР” системээс шаардлагатай зарим мэдээлэл, лавлагаа авах боломжийг бүрдүүлсэн, цахимаар үзүүлэх үйлчилгээний тоо, хүртээмжийг нэмэгдүүлсэн зэргээр “Цахим үндэстэн” болох арга хэмжээг эрчимжүүлсэн.

Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран иргэд, олон нийтийг согтууруулах ундааны хорт зуршил, буруу хэрэглээнээс татгалзуулах, түүнээс үүдэн гарах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулсан “Намайг алгас” аян Монголын маркетингийн холбоо, “Unread” төрийн бус байгууллага хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг нийгмийн шилдэг төсөл шалгаруулах “Unread awards”-ын “Шилдэг санал, санаачилга төрөл”-д шалгарсан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг чиглүүлэх, тэднээс хариу дэмжлэг авахад маркетингийн удирдлага, брэндингийн олон нийтийн анхаарлыг татах, оюун санаанд нь тодорхой ойлгомжтой мессэж хүргэх, цар хүрээг нь нэмэгдүүлэх, зөв үйл, дадлыг хэрэгжүүлэхэд өдөөх арга, технологийг амжилттай ашиглаж байгаагийн илрэл юм.

Цаашид хүрсэн амжилтаа бататгаж, үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, тавьсан зорилтдоо амжилттай хүрэхэд төсөв, санхүү дутагдал, удирдлага, зохион байгуулалтын жигд бус ажиллагаа нөлөөлөхөөс сэргийлж, шаардагдах зардлыг урьдчилан төсөвлөх, төсөвт тусгуулж, хэрэгжүүлэх, гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төсөл, хөтөлбөрт хамруулах боломж, арга замыг эрэлхийлэх, алдаа, дутагдлаа эрт илрүүлэх, шүүрхай арга хэмжээ авч байхын тулд хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмолжуулж, чанартай хийж, гүйцэтгэж байх;

Албан хаагчдын эрх ашгийг хамгаалахын зэрэгцээ байгууллагын гүйцэтгэлийг сайжруулж, албан хаагчдын урам зоригийг бадраах, байгууллагын үйл ажиллагааны уян хатан байдал, алба хаагчийн ур чадвар, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх, дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх, одоогийн албан хаагчдын мэргэжлийн өсөлт хөгжлийг дэмжих, ур чадварыг тодорхойлох, бүрэн дүүрэн ашиглахгүй байгаа ур чадварыг олж тогтоох, чадавхийг нь бүх түвшинд бэхжүүлэхэд анхаарах;

Үйл ажиллагааны “Дижитал шилжилт”-ийг эрчимжүүлэх, байгууллагын удирдлагын цахим ойлголт, алба, нэгжүүдийн цахим боловсролын түвшинг тогтоон, шинээр шаардагдах ур чадваруудыг тодорхойлж, эзэмшүүлэх, алба хаагчдын идэвхи, оролцоог нэмэгдүүлэх, өөрчлөлтөөс бий болсон ашигт ажиллагаа, үйл ажиллагааны өгөөжийг тооцож, сурталчлах;

Судалгаа, дүн шинжилгээний ажлыг чанаржуулж, үр дүнг практик үйл ажиллагаанд нэвтрүүлж, ашиглах;

Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолоор баталсан “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр” Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцээгүй, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд хөтөлбөрт тодорхойлсон үйл ажиллагааг бүрэн тусгаагүй, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн жагсаалтад багтаагүйгээс санхүүжилтгүй байгаа тул хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх талаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд санал хүргүүлж, чиглэл авах зэрэг болно.

Салбарын журамд зааснаар яаманд хүргүүлснээс бусад хэрэгжилтийн тайланг энэ тайланд хавсаргасан ба Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өгсөн ажлын чиглэлийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 189 дүгээр тушаалаар баталж, 2022 оны А/107 дугаар тушаалаар хүчингүй болсонд тооцсон “Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлт”-ийг 2022 оны жилийн эцсийн байдлаар гаргаж¹, байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, тайланг Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн хуралдааны тэмдэглэлийн² хамт тус тус хавсаргав.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

¹ Тайлангийн 4 дүгээр хавсралт

² Тайлангийн 5 дугаар хавсралт